

ЗАСАГ ДАРГА, БАТЛАВ Д.ЛХАГВАДОРЖ

**ЦАГААН БУЛАГ ХОРООЛОЛ РУУ ГЭРЭЛТҮҮЛЭГ ХИЙХ  
АЖЛЫН ТАВИГДАХ ШААРДЛАГА**

1. Сумын төвийн гудамж гэр хороололын гэрэлтүүлэгийг шинэчлэх ажлыг Монгол улсын Эрчим хүчний тухай хууль, Гудамж талбайн гэрэлтүүлэгийн стандартад нийцүүлэн хийвэл зохино.
2. Гэрэлтүүлэгийн гэрэл нь led цагаан өнгөтэй, 100вт түүнээс дээш чадалтай байна.
3. Гэрлийг тогны утас дамжуулж буй шон, ган төмөр дээр байрлуулна.
4. Гэрлийн утас сип нь АББГ 2\*6 загварын монгол улсын стандартын шаардлагыг хангасан байвал зохино.
5. Гэрэлтүүлэгийг тавихад шаардлагатай дагалдах хэрэгслүүд /салбарлагч, сип, тусгаарлагч лент, татагч, электрод, багцлагч, баригч, боолтнууд, шит нь гэрэлтүүлэгийн төсөвт заасан хэлбэр загварын байна.
6. Нийт 75 гэрлийг хийж тогтоож, суурилуулна.
7. Цагаан булаг, Дарь эхийн хороололын арын гудамаар гэрэлтүүлэггүй газраар хийнэ.

**ТЕНДЕРТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

Гэрэлтүүлэгийг хийх хугацаа: Тендерийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан аж ахуйн нэгж нь гэрэлтүүлэг хийх ажлыг гэрээ байгуулсан өдрөөс хойш 1-2 сарын хооронд хэрэгжүүлнэ. Заасан хугацаанд хэрэгжүүлээгүй бол хоног тутамд төсөвт өртгийн нийт дүнгээс 0,03 хувийн алдангийг захиалагч байгууллагад төлнө. /гэрээнд оруулна/

Гэрээг хэрэгжүүлэгч нь орон нутгаас шинэ ажлын байранд 3 хүртэл хүнийг авч ажиллуулна.

Гудамж талбайд гэрэлтүүлэг хийх ажлыг стандартын шаардлагад нийцүүлэн хийгээгүй тохиолдолд захиалагч байгууллага хүлээн авахгүй бөгөөд Захиалагчийн заасан хугацаанд /45 хоног/-т стандартад нийцүүлэн хийж хүлээлгэн өгөх ажлыг гүйцэтгэгч байгууллага хариуцна.

Захиалагчийн заасан хугацаанд гэрээт ажлын дутагдлыг засаж гүйцэтгээгүй тохиолдолд үүссэн хохиролыг гүйцэтгэгч тал барагдуулах буюу гэрээний нийт үнийг эргүүлэн төлнө.

**ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО**